



**“УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

**Албан тушаалын тодорхойлолтыг
шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн “Компанийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 09 дүгээр тогтоол, нийслэлийн өмчит “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн өмчит “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн бүтэц, орон тоо шинэчлэн баталсантай холболтойгоор ерөнхий менежерийн албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр хавсралтаар, бусад албаны дарга, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтыг ажил мэргэжлийн жагсаалтын дагуу ажилтан тус бүрд танилцуулж, баталгаажуулан хувийн хэрэгт хавсаргахыг Үйл ажиллагаа, зохион байгуулалтын алба (Г.Сүнжидмаа), албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан гүйцэтгэх захирлын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.ХУЛАН

1725020012